

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.12 заалтад үндэслэн газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Журамд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон эзэмшигч бус ашигт малтмалыг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бүх аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд хамаарна.

ХОЁР. ЖУРМЫН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. “ашигт малтмалыг баяжуулах” гэж анхдагч болон үүсмэл ордоос ашигт эрдсийг ялгах, баяжуулах, боловсруулах үйл ажиллагааг;
- 2.2. “баяжуулах цех” гэж ашигт малтмалыг ялгах, баяжуулахад зориулан зохион байгуулсан технологийн дамжлага болон бичил уурхай эрхлэгч этгээдэд зориулсан тоног төхөөрөмжийн иж бүрдлийг;
- 2.3. “баяжуулах үйлдвэр” гэж ашигт малтмалыг иж бүрэн баяжуулах зорилгоор зохион байгуулсан цехүүдийн иж бүрдлийг;
- 2.4. “технологийн заавар” гэж бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах технологийн процессын дэс, дараалал, үйлдвэр, цехийн зөв ажиллах дүрэм, боловсруулалтын арга зэргийг тусгасан иж бүрэн баримт бичгийг;
- 2.5. “техник, эдийн засгийн үндэслэл” гэж техник, технологи, эдийн засгийн тооцоо, зураг, төсөв, тайлбар бичгийг;
- 2.6. “баяжуулах үйлдвэрийн техникийн зураг төсөл” гэж баяжуулах үйлдвэр, түүний цех, хэсэг, өргөтгөлийг барьж байгуулахад шаардлагатай тооцоо, судалгаа зэрэгт үндэслэсэн холбогдох бусад материалаас бүрдэх техникийн иж бүрэн баримт бичгийг;
- 2.7. “баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл” гэж Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа явуулахыг аж ахуйн нэгжид зөвшөөрсөн захирамжийн баримт бичгийг;
- 2.8. “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж ашигт малтмалын тухай хууль болон аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах эрх авсан эсхүл түүнийг холбогдох бусад хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээдийг;
- 2.9. “баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч” гэж ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болон баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийг;

ГУРАВ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

- 3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.12-д заасны дагуу баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага хяналт тавина.
- 3.2. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг:
 - 3.2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах үйлдвэрт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.6; 7.1 дүгээр заалтын дагуу **“БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ”**-ийг олгоно.
 - 3.2.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.2.1 дүгээр заалтад заасан тусгай зөвшөөрлийг авах шаардлагагүй.
- 3.3. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг:
 - 3.3.1. Баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих;
 - 3.3.2. Баяжуулах үйлдвэрийн байршлыг уул уурхайн кадастрын системд бүртгэх;
 - 3.3.3. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
 - 3.3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сар бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийг нэгтгэж, улирал бүр Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.
- 3.4. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллага хяналт тавьж ажиллана.

ДӨРӨВ. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, стандартуудын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй ажиллагаа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн технологийн үндсэн шаардлагыг хангасан байх.
- 4.2. Баяжуулах үйлдвэр, цех нь дэвшилтэд техник, технологийг нутагшуулах, туршилт судалгааг тасралтгүй хийх.
- 4.3. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудыг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хортой, аюултай бодисын агууламж, үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшний тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх.
- 4.4. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр Техник, эдийн засгийн үндэслэл болон Баяжуулах үйлдвэрийн техникийн зураг төслийг хамт хэлэлцүүлж, батлуулсан байх.
- 4.5. Үйлдвэрлэсэн баяжмал дахь үнэт бүрдлээс гадна дагалдах ашигт нэгдлүүдийг металлын агууламжийг байнга тодорхойлох.

- 4.6. Газар, ус, цахилгаан зэрэг баяжуулах үйлдвэрийн дэд бүтэцтэй холбоотой зөвшөөрөл авах, шаардлага тохиолдолд гэрээ хийсэн байх.
- 4.7. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр зураг, төсөл баталгаажуулах эрх бүхий байгууллагаас баталсан баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжийн зураг төсөл хийлгэсэн байх.
- 4.8. Баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжийг ашиглалтад авсан Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг гаргуулсан байх.
- 4.9. Үйлдвэрийн гадаад орчинд тавих шаардлага нь доорх үзүүлэлтийг хангасан байна.
 - 4.9.1. Байгууллагын хаяг
 - 4.9.2. Цардсан зам, талбайтай, зүлэгжүүлэлт, тохижилт хийгдсэн, шөнийн гэрэлтүүлэгтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан гадна орчин
 - 4.9.3. Үйлдвэрлэлээс гарсан хог, хаягдлыг түр хадгалах тусгайлан зассан хогийн цэг
 - 4.9.4. Бүтээгдэхүүн, материал, химийн бодисыг зөөвөрлөх, ачиж буулгах зориулалтын цардсан зам, талбай, химийн бодис хадгалах агуулахтай байх
 - 4.9.5. Үйлдвэрийн байршлын зураг
- 4.10. Үйлдвэр, цехийн ажлын байранд тавих шаардлага нь доорх үзүүлэлтийг хангасан байна.
 - 4.10.1. Ажлын байрны тодорхойлолт
 - 4.10.2. Технологийн дамжлага бүр мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан байна.
 - 4.10.3. Хүний нөөцийг хоёр жил тутамд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.
 - 4.10.4. Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн дүрэм
 - 4.10.5. Технологийн хаягдал ус гадагш гарах суваг бүхий дамжлагын хэсэг
 - 4.10.6. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах инженерийн шугам, сүлжээ
 - 4.10.7. Ажлын байрны дүгнэлт
- 4.11. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч дараах баримт бичгийг үйлдвэр дээр байлгана:
 - 4.11.1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ (хуулбар);
 - 4.11.2. Баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл (хуулбар);
 - 4.11.3. Химийн болон хортой бодис ашиглах тусгай зөвшөөрөл;
 - 4.11.4. Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл;
 - 4.11.5. Баяжуулах үйлдвэрийн зураг төсөл;
 - 4.11.6. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, сар, улирал, долоо хоногийн мэдээ;
 - 4.11.7. Ослоос урьдчилан сэргийлэх, устгах төлөвлөгөө;
 - 4.11.8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;
 - 4.11.9. Байгаль орчныг хамгаалах, менежментийн төлөвлөгөө;
 - 4.11.10. Үйлдвэрлэлийн болон хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт болон төлөвлөгөөт хяналт, сорьцолтын тайлан;
 - 4.11.11. Газар ашиглах тухай гэрээ;

- 4.11.12. Ус ашиглах тухай гэрээ;
 - 4.11.13. Цахилгаан ашиглах гэрээ;
 - 4.11.14. Хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ;
 - 4.11.15. Үйлдвэрийн үндсэн түүхий эдийг худалдан авах гэрээ, хэлцэл;
 - 4.11.16. Ажил гүйцэтгэх зааварчилга;
 - 4.11.17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, сургалтын бүртгэл;
 - 4.11.18. Баяжуулах үйлдвэрийн ажилчдын судалгаа (Мэргэжлийн боловсон хүчин, орон нутгаас ажиллагсдын мэдээлэл);
 - 4.11.19. Технологийн баяжуулалтын үеийн алдагдал, хаягдлыг өөрсдөө болон итгэмжлэгдсэн байгууллагын тогтоосон тайлан болон хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан.
- 4.12. Баяжуулах үйлдвэр, цех нь технологийн заавартай байх бөгөөд 5 жил тутамд шинэчлэн үйлдвэр, хэсгийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсан байх.
- 4.13. Баяжуулах үйлдвэр, цех нь тоног төхөөрөмж бүр дээр тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортыг хөтлөх.
- 4.14. Хаягдлын аж ахуйн хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэнэ.

ТАВ. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ СОРЬЦЛОЛТ

- 5.1. Ордын нөөцийг зүй зохистой иж бүрэн ашиглах, хаягдал бохирдлыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор технологийн дотоод хяналт сорьцлолтыг сар бүр хийнэ.
- 5.2. Стандарт, хэмжил зүйн байгууллагаас итгэмжлэл авсан лабораториор баяжуулах үйлдвэр, цех, хэсгийн алдагдал хаягдлыг тогтоох хөндлөнгийн технологийн хяналт сорьцлолтыг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгүүлнэ.

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

ЗУРГАА. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.11 дүгээр заалтын дагуу Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг баримтлан Улсын комисс томилох;
- 6.2. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах, санал дүгнэлт гаргах, шалгалт хийх удирдамжаар ханган, томилох

ДОЛОО. АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон комисс үйлдвэрийг хүлээж авснаас дараа баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйлдвэрийг ажиллуулж эхэлнэ.

- 7.2. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйлдвэрлэлийн болон хагас үйлдвэрлэлийн технологийн туршилтыг үндэслэж, ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төслийг боловсруулж, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр зөвшөөрүүлэх;
- 7.3. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.2, 48.6.3 дугаар заалтуудын дагуу дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт болон тухайн жилийн тайланг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- 7.4. Энэ журмын 5.2 дугаар заалтад заасан хөндлөнгийн технологийн хяналт сорьцлолт хийлгэсэн тайланг тухайн жилийн ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны тайланд хавсаргаж Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;
- 7.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Геологи, уул уурхайн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан баяжуулах үйлдвэртэй холбоотой аюулгүй ажиллагааны дүрэм, холбогдох журам, стандартыг чанд баримтлах;
- 7.6. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг баяжуулах үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах бөгөөд дараах үүрэг хүлээнэ:
 - 7.6.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;
 - 7.6.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ашигт малтмал баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;
 - 7.6.3. Баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан нөлөөллийг тухай бүр нь бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн болон тайланг жил бүр гарган Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлнэ.
- 7.7. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны үйлдвэрийн бүсэд ажиллах нөхцөлийг томилолт, удирдамжийн дагуу хангах;
- 7.8. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу гарал үүсэл нь тодорхой ашигт малтмалыг баяжуулах үйлдвэр, цех нь худалдан авч болно.
- 7.9. Худалдан авч баяжуулсан ашигт малтмалын Ашигт малтмалын нөөц ашигласан төлбөрийг тухайн баяжуулах үйлдвэр улсын төсөвт төлнө.
- 7.10. Дагалдах элементийн Ашигт малтмалын нөөц ашигласан төлбөрийг улсын төсөвт төлнө.
- 7.11. Эх үүсвэр нь тодорхойгүй ашигт малтмалыг баяжуулахгүй байх;
- 7.12. Баяжуулах үйлдвэр, цехэд хэрэглэх химийн хорт болон аюултай бодисыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгахад “Химийн хорт болон аюултай бодисын тухай” Монгол Улсын хууль, “Химийн хорт болон

- аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгах дүрэм, журам"-ыг баримтлах;
- 7.13. Хаягдлын аж ахуйн зураг төслийг тооцоо судалгааны үндсэн дээр боловсруулах бөгөөд Техник, эдийн засгийн үндэслэлийн салшгүй хэсэг байна.
- 7.14. Хаягдлын аж ахуйн зураг төсөл тусгагдсан цэвэр, бохир усны нуур, цөөрмийг үүсгэхдээ Усны барилга байгууламжийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг баримтлах.

НАЙМ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН ОРОЛЦОО

- 8.1. Бичил уурхай эрхлэгч хуулийн этгээд нь хүдрээ баяжуулсан тухайн баяжуулах цехийн хаягдлыг гүйцээн баяжуулах, зарж борлуулахад үүсэх харилцаанд оролцох эрхтэй.
- 8.2. Баяжуулах цехийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд ашигт эрдсийн хаягдлыг хамгийн бага байлгах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 8.3. Бичил уурхай эрхлэгч этгээд нь баяжуулах цехэд ажиллахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг чанд мөрдөнө.

ЕС. ҮЙЛДВЭРИЙГ ТҮР БА БҮР МӨСӨН ХААХ

- 9.1. Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлийн дагуу үйлдвэрийн бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хаах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

АРВАН. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 10.1. Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.